Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

**Дархан-Уул аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газар**

## 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**2024.12.05**

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 1.1. | Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлох, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох. | Батлагдсан төсвийн хүрээнд | Санал өгөх дүрэм, журам, стандартын тоо | 4 хууль, 2 журам, 1 стандартын төсөлтэй танилцан санал өгсөн. Шинээр 1 журам боловсруулан батлуулсан. | Шинээр болон шинэчлэн боловсруулж буй хууль тогтоомжид санал өгч, хэрэгжилтийг хангуулна. Шинээр 2 журам, 1 журмыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангуулна. | 1.Шинээр боловсруулсан 4 журам, 1 дүрэм, 1 үндэсний хөтөлбөр, 1 төлөвлөгөө, 1 стандарт, 1 аргачлал, батлагдсан 1 хууль, 6 журамд нэмэлт өөрчлөлт оруулахаар боловсруулсан төсөлтэй тус газрын болон соёлын байгууллагуудын албан хаагчдад танилцуулж, 70 санал гаргасныг нэгтгэн хэлэлцүүлж, ССАЖЗЯ, ЗГХАСУГ, Аймгийн ЗДТГ, ТАЗСЗ-д албан бичгээр хүргүүлж, цахимаар илгээсэн. Үүнд: 2 заалтыг хасах, 15 заалт нэмэх, 53 заалтыг өөрчлөлт оруулах санал ирүүлсэн. 1 дүрэм, 1 аргачлал, 3 журмын төсөлд саналгүй болно. 2. ТАЗ-ийн Дархан-Уул аймаг дахь Салбар зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу дараах арга хэмжээнүүдийг авч ажиллалаа. Үүнд: 1-рт: Тус газрын даргын 2024.02.23-ны өдрийн А/05 дугаар тушаалаар “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэгдүгээр хавсралтаар, “Цалин хөлсний журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Албан томилолтын журам”-ыг гуравдугаар хавсралтаар, “Зайнаас ажиллах үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсан. Дээрх журмуудын төслийг боловсруулан нийт албан хаагчдаас санал авч хэлэлцүүлсэн болно. 2-рт: ХЭҮК-оос боловсруулсан аргачлалын дагуу ажил олгогчийн хүний эрх, хүний эрх хамгаалагчийн талаар хүлээсэн үүрэгтэй холбоотой 3 заалт, албан хаагчийн хүний эрх, хүний эрх хамгаалагчийн эрхтэй холбоотой 3 заалтыг боловсруулан нийт албан хаагчдад танилцуулан санал авч, тус газрын даргын 2024.07.05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.<br>Хавсралт: 7 файл | |
| 1.1.1 | Соёлын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, стандарыг хуульд нийцүүлэн шинэчлэхэд санал өгөх, хэрэгжилтийг хангуулах. | Батлагдсан төсвийн хүрээнд | Санал өгөх дүрэм, журам, стандартын тоо | 4 хууль, 2 журам, 1 стандартын төсөлтэй танилцан санал өгсөн. | Эхний хагас жилд: Шинээр болон шинэчлэн боловсруулсан хууль тогтоомжид санал өгч, хэрэгжилтийг хангуулна. Жилийн эцэст: 2-оос доошгүй шинээр болон шинэчлэн | 1. ТАТХ-ийн хэрэгжилтэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, сайжруулах арга хэмжээний талаар 10 санал гарсныг нэгтгэн нийт албан хаагчдаар хэлэлцүүлсэн. 2. “ТАХ-дыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн танилцуулга, төслийг соёлын байгууллагуудад хүргүүлж, ирүүлсэн 11 санал /хасах 1, өөрчлөлт оруулах 10/-ыг нэгтгэн дотооддоо хэлэлцүүлсэн. 3. Хувийн хэвшил, ТББ-аар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай МУЗГ-ын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах 2024 оны төлөвлөгөөний төсөлд тус газрын харьяа соёлын 6 байгууллагаас санал ирүүлснийг хянаж нэгтгэн хүргүүлсэн. 4. ЁЗДХ-ны ажиллах журмын төслийг нийт албан хаагчдад | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулсан хууль тогтоомжид санал өгч, хэрэгжилтийг хангуулна. | танилцуулж, 11 санал /нэмэх 1, өөрчлөлт оруулах 10/ гарсныг нэгтгэн хүргүүлсэн. 5. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан 2 журмын төсөлтэй танилцаж, 1 заалтыг хасах, 10 заалтад өөрчлөлт оруулахаар санал гаргасныг нэгтгэн хүргүүлсэн. Үүнд: “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”, “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам” болно. 6. "ТЖАХ-ийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам", "ТЖАХ-д сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын төсөлтэй танилцаж, 4 заалт нэмэх, 7 заалтад өөрчлөлт оруулах санал гарсныг нэгтгэн хэлэлцүүлсэн. 7. "Төрийн албаны үйл ажиллагааны стандартад тавигдах ерөнхий шаардлага MNS...2024" стандартын төсөлтэй танилцаж, 3 заалт нэмэх, 3 заалтыг өөрчлөх саналыг нэгтгэн ССАЖЗЯ-нд хүргүүлсэн. 8. ЗГ-ын Хяналт үнэлгээний үндэсний хорооноос зохион байгуулсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын шинэчилсэн журмын хэлэлцүүлэгт цахимаар оролцож 1 санал өгсөн. 9. Хүүхэд хамгааллын тухай хуульд нийцүүлэн боловсруулан "Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам"-ын төслийг харьяа соёлын байгууллагуудад хүргүүлсэн ба өөрчлөлт оруулахаар ирүүлсэн 3 саналыг нэгтгэн хүргүүлсэн.<br><br>Хүрсэн түвшин: Шинээр боловсруулсан 4 журам, 1 дүрэм, 1 үндэсний хөтөлбөр, 1 төлөвлөгөө, 1 стандарт, 1 аргачлал, батлагдсан 1 хууль, 6 журамд нэмэлт өөрчлөлт оруулахаар боловсруулсан төсөлтэй тус газрын болон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | соёлын байгууллагуудын албан хаагчдад танилцуулж, 70 санал гаргасныг нэгтгэн хэлэлцүүлж, ССАЖЗЯ, ЗГХАСУГ, Аймгийн ЗДТГ, ТАЗСЗ-д албан бичгээр хүргүүлж, цахимаар илгээсэн. Үүнд: 2 заалтыг хасах, 15 заалт нэмэх, 53 заалтыг өөрчлөлт оруулах санал ирүүлсэн. 1 дүрэм, 1 аргачлал, 3 журмын төсөлд саналгүй болно.<br>Хавсралт: 5 файл | |
| 1.1.2 | Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн байгууллагын дотоодод мөрдөгдөх журмыг шинээр болон шинэчлэн боловсруулах, батлуулах. | Батлагдсан төсвийн хүрээнд | Боловсруулж батлуулсан журмын тоо | Шинээр 1 журам боловсруулан батлуулсан. | Эхний хагас жилд: Шинээр журам шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангуулна. Жилийн эцэст: Шинээр 2 журам, 1 журмыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангуулна. | ТАЗ-ийн Дархан-Уул аймаг дахь Салбар зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу дараах арга хэмжээнүүдийг авч ажиллалаа. Үүнд: 1-рт: Тус газрын даргын 2024.02.23-ны өдрийн А/05 дугаар тушаалаар “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн нэгдүгээр хавсралтаар, “Цалин хөлсний журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Албан томилолтын журам”-ыг гуравдугаар хавсралтаар, “Зайнаас ажиллах үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсан. Дээрх журмуудын төслийг боловсруулан нийт албан хаагчдаас санал авч хэлэлцүүлсэн болно. 2-рт: ХЭҮК-оос боловсруулсан аргачлалын дагуу ажил олгогчийн хүний эрх, хүний эрх хамгаалагчийн талаар хүлээсэн үүрэгтэй холбоотой 3 заалт, албан хаагчийн хүний эрх, хүний эрх хамгаалагчийн эрхтэй холбоотой 3 заалтыг боловсруулан нийт албан хаагчдад танилцуулан санал авч, тус газрын даргын 2024.07.05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.<br>Хүрсэн түвшин: Байгууллагын дотоодод мөрдөгдөж буй 1 журмыг холбогдох хууль | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоомжид нийцүүлэн шинэчилж, 1 удаа нэмэлт өөрчлөлт оруулж, 3 журмыг шинээр боловсруулан батлуулсан. Албан хаагчид байгууллагын дотоодод мөрдөгдөж буй журмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжилтийг бүрэн хангуулж зөрчилгүй ажилласан.<br><br>Хавсралт: 3 файл | |
| 1.2. | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт, хамгаалалт, гадна өнгө төрх, сэргээн засварлалтын ажлыг сайжруулна. | Батлагдсан төсөв | Гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийн тоо, сэргээн засварласан дурсгалт зүйлсийн тоо арга хэмжээний тоо, бүртгэлд хамрагдсан баримтат өвийн тоо, тоологдсон түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоо | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтын гэрээг 3 байгаль хамгаалагч, 3 малчин иргэнтэй байгуулж ажилласан. Түүх, соёлын үл хөдлөх 2 дурсгалт зүйлс, музейн 3 үзмэрийн гадаад өнгө төрхийг сэргээн засварласан. 2 сумын соёлын төвийн музейд 4 удаа түр үзэсгэлэн дэглэж, 5 удаа мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. 50 дэсийн 51 баримтат өвийг | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтыг гэрээний үндсэн дээр 3 хувь хүн, хуулийн этгээдээр хийж гүйцэтгүүлнэ. Түүх, соёлын үл хөдлөх 3 дурсгалт зүйлсийг сэргээн засварлуулна. Сумдын Музейд 5-аас доошгүй түр үзэсгэлэн дэглэх болон Музейн ажилтанд мэргэжил арга зүйн | Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Аймгийн Засаг даргын 2024.07.03-ны өдрийн 01-А/315 дугаар захирамжаар 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Аймгийн ЗДТГ-ын даргын 2024.08.06-ны өдрийн 02-А/139 дүгээр тушаалаар 28.0 сая төгрөгийн, ЗГХАСУГ-ын даргын 2024 оны А/32, А/58 дугаар тушаалаар нийтдээ 20.0 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгогдсон. Энэ хүрээнд 31 заалт бүхий төлөвлөгөө гарган аймгийн Засаг даргын орлогчоор батлуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулж тайлагнасан. Дархан-Уул аймгаа төлөөлөн оролцох "Найрамдлын Дархан" отгын зохион байгуулагчаар Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Энхбаярыг тус газрын даргын 2024.08.12-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар томилж, баг бүрэлдэхүүнийг өндөр түвшинд зохион байгуулж, бусад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг үүрэгжүүлж биелэлтийг бүрэн хангуулсан.<br>Хавсралт: 6 файл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | судалгаанд хамруулсан. 2019 онд 969 дэсийн 1362 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тоологдсон. | чиглэл өгнө. 50-иас доошгүй баримтат өвийг судалгаанд хамруулна. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг бүрэн хийж, холбогдох газарт тайлагнасан байна. | | |
| 1.2.1 | Аймгийн нутаг дэвсгэрт орших улсын болон аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтыг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийн тоо | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтын гэрээг 3 байгаль хамгаалагч, 3 малчин иргэнтэй байгуулж ажилласан. | Эхний хагас жилд: Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтыг гэрээний үндсэн дээр хувь хүн, хуулийн этгээдээр хийж гүйцэтгүүлнэ. Жилийн эцэст: Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн | 1. Хонгор сумын нутагт орших 5 ширхэг Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг аймгийн Музейн бүртгэл мэдээллийн санд шинээр бүртгэв. Бүртгэлд 3 хөшөө дурсгал, 1 үйлдвэрлэлийн ул мөрийн дурсгал, хиргисүүрийг тус тус тусгай маягтын дагуу бүрдүүлэн ажиллаж, гэрэл зургаар баримтжууллаа. 2. Соёлын өвийн үндэсний төвөөс Дархан таван нуур ХХК-ийн ойролцоо Хүннүгийн үеийн булш байна гэсэн мэдээллийн дагуу Музей, Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран тус газарт очиж 4 ширхэг 7*7 харьцах хэмжээтэй булшийг бүртгэн баримтжуулав. 3. Шарын гол сумын Хайрхан багийн нутаг дэвсгэрт орших "Буган чулуун хөшөө" дурсгалыг Хайрхан багийн иргэн Д.Мядагсүрэн, “Найрамдал өндөрлөг” хөшөөг “Цэгц туургатан” ХХК-д эзэмшүүлж гэрээгээр хамгаалах, хамтран ажиллах 3 талт гэрээг байгуулж ажиллав. 4. Дархан сумын 14 дүгээр багийн нутаг дэвсгэрт орших Түүх, соёлын үл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хадгалалт хамгаалалтыг гэрээний үндсэн дээр 3 хувь хүн, хуулийн этгээдээр хийж гүйцэтгүүлнэ. | хөдлөх дурсгал болох "Найрамдал" өндөрлөг, "Лимбэчин хүү", "Эх үрсийн элбэрэл", "Буга" баримал хөшөөг Дархан хотын соёл, амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-т гэрээгээр эзэмшүүлж хамгаалах, хамтран ажиллах 3 талт гэрээг байгуулав. Цаашид хэрэгжүүлэх ажил болох "Лимбэчин хүү", "Эх үрсийн элбэрэл" хөшөөний гадна өнгө төрхийг сэргээн засварлах ажил төсвийн талаар хэлэлцэв. 5.Хонгор сумын 2 дугаар багт орших 23 дурсгалыг тус сумын 3 байгаль хамгаалагчид гэрээгээр хариуцуулж өгөх 3 талт гэрээг Хонгор сумын засаг даргын тамгын газар, Соёлын төвийн дарга, Байгаль хамгаалагч нар байгуулж ажиллав.<br>Хүрсэн түвшин: Тайлант хугацаанд түүх, соёлын үл хөдлөх дурсгал 29 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг 5 хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулан хамгаалуулав. "Лимбэчин хүү", "Эх үрсийн элбэрэл" хөшөөний гадна өнгө төрхийг сэргээн засварлах ажлын төсвийг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХэлтэст 2025 орон нутгийн төсөвт суулгуулахаар санал хүргүүлэв.<br>Хавсралт: 5 файл | |
| 1.2.2 | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн гадаад өнгө төрхийг сэргээн засварлах ажлыг эхлүүлнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | Сэргээн засварласан дурсгалт зүйлсийн тоо | Түүх, соёлынүл хөдлөх 2 дурсгалт зүйлс, музейн 3 үзмэрийн гадаад өнгө төрхийг сэргээн засварласан. | Эхний хагас жилд: Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг сэргээн засварлуулна.<br>Жилийн эцэст: Түүх, соёлын үл | 1.Соёлын Өвийн Үндэсний Төвд сэргээн засварлах шаардлагатай үзмэрийн судалгааг гаргаж, 35 дэсийн 38 ширхэг уран зураг засварлуулах хүсэлт хүргүүлсэн. Тус хүсэлтийн дагуу СӨҮТ-өөс 2024 оны 05/21 тоот албан бичгээр "Ачаа ачигч", "Мөнх найрамдлын тууль", "Мөнх найрамдал", "Давхарын өртөө", "Их нүүдэл", "Үйлдвэрийн Дархан" зэрэг 6 уран зургийг СӨҮТ рүү актаар хүлээлцэн хүргэх ажлыг соёлын өвийг зөөж тээвэрлэх журмын дагуу гүйцэтгэсэн. 2. 2024 оны 01 дүгээр сард сэргээн засварлагдсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөдлөх 3 дурсгалт зүйлсийг сэргээн засварлуулна. | авдар, хул аяга, морин хуур зэрэг 3 үзмэрийг хүлээн авч сан хөмрөгт хадгалав. 3. Дархан-Уул аймгийн нутагт орших нурж унах эрсдэлд орсон 2, унаган газраас зөөгдсөн 2, төв суурин газар, бүтээн байгуулалтад өртөж эх төрх нь алдагдсан 3, Улсын болон хөдөө орон нутгийн замд өртсөн 4, бичиж балласан, сийлж сүйтгэсэн 1, хадаг бөс даавуугаар ороосон, сүү тосны бохирдолд орсон 1 зэрэг Түүх Соёлын Үл Хөдлөх Дурсгалуудын мэдээллийг бэлтгэж СӨҮТ-д хүргүүлэв.<br><br>Хүрсэн түвшин: 1. Соёлын өвийн 3 үзмэрийг сэргээн засварлуулсан. хүлээн авч сан хөмрөгтөө хадгалсан. Сан хөмрөгт хадгалагдаж байсан 6 уран зургийг СӨҮТ-д илгээсэн. 2. Эрсдэлд орсон аюултай түвшинд хүрсэн яаралтай хамгаалах шаардлагатай түүх соёлын үл хөдлөх 13 дурсгалын жагсаалтыг гарган СӨҮТ-д хүргүүлэв.<br><br>Хавсралт: 5 файл | |
| 1.2.3 | Сумдын Музейд үзмэр дэглэх, мэргэжил арга зүйн чиглэл өгөх, орон нутгийн иргэдэд соёлын өвийг сурталчлах ажлыг хамтарч зохион байгуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээний тоо | 2 сумын соёлын төвийн музейд 4 удаа түр үзэсгэлэн дэглэж, 5 удаа мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. | Эхний хагас жилд: Сумдын Музейд түр үзэсгэлэн дэглэх болон Музейн ажилтанд мэргэжил арга зүйн чиглэл өгнө. Жилийн эцэст: Сумдын Музейд 5-аас доошгүй түр | 1. Аймгийн Музейгээс Орхон, Шарын гол сумдын Соёлын Төвийг түшиглэн “Хөөрхөн Надатай цуг хөлөгт тоглоом тоглоцгооё” уламжлалт тоглоом наадгайг сурталчилах өдөрлөг, түр үзэсгэлэнг сумдын ард иргэд, хүүхэд залуучуудад дэлгэн толилуулав. Тус түр үзэсгэлэнг 350 хүүхэд залуучууд үзсэн. 2. Орхон сумын Соёлын төвийн албан хаагчдад соёлын өвийн бүртгэл мэдээллийн маягт хөтлөх, гэрэл зураг хадгалах, СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг хэрхэн бүртгэх талаар сургалт зохион байгуулсан. 3. Шарын гол сумын Соёлын төвд 7 түр үзэсгэлэн дэглэж, албан хаагчдад “Соёлын Биет Бус Өвийн тухай танилцуулга болон Дархан-Уул аймгийн тоон мэдээлэл”, “Соёлын баримтат өвийн тухай, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзэсгэлэн дэглэх болон Музейн ажилтанд мэргэжил арга зүйн чиглэл өгнө. | түүнийг хэрхэн бүртгэн баримтжуулах" болон "Түүх, Соёлын Хөдлөх дурсгалын төрөл зүйлийн танилцуулга" сэдвүүдээр сургалт зохион байгууллаа. 4. Хонгор сумын Соёлын төвийн албан хаагчдад "Түүх, Соёлын Үл Хөдлөх Дурсгал"-ыг бүртгэн баримтжуулах талаар тус тус арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. 5. Орхон сумын Соёлын төвд Музейн шинэ танхим тохижуулах гэж буйтай холбогдуулан холбогдох мэдээ, материалыг илгээж, зөвлөн туслаж арга зүйгээр хангаж ажилласан. 6. Хараагийн Дарь эхийн Гэцогдаржайлин хийдэд хадгалагдаж буй соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, баримтад өвийн талаар арга зүйн сургалтыг зохион байгуулан ажиллав.<br>Хүрсэн түвшин: Орхон, Шарын гол, Хонгор сумдын Соёлын төвд уламжлалт тоглоом наадгайг сурталчлах өдөрлөг зохион байгуулж 10 түр үзэсгэлэнг дэглэж 350 хүн хамрагдав. Орхон, Хонгор сумын Соёлын төвийн Музейн албан хаагчдад үзмэр дэглэх тухай СУАЖЗГ-аас зөвлөн туслах мэргэжил арга зүйн зөвлөгөөг 3 удаа, Музейгээс Орхон, Хонгор, Шарын гол сумдын Соёлын төвийн албан хаагчдад соёлын өвийг сурталчлах мэдлэг олгох сургалтыг 3 удаа зохион байгуулсан.<br>Хавсралт: 16 файл | |
| 1.2.4 | Иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэлд хамруулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Бүртгэлд хамрагдсан баримтат өвийн тоо | 50 дэсийн 51 баримтат өвийг судалгаанд хамруулсан. | Эхний хагас жилд: баримтат өвийг судалгаанд хамруулсан байна. Жилийн | Сүм хийд, иргэдийн гар дээр хадгалагдаж буй баримтат өвийг бүртгэх ажлын хүрээнд: Үүнд: - Дархан сумын 12 дугаар багийн иргэн Х.Мөнхцэцэгт аав З.Хашхүүгээс өвлөгдөн ирсэн "Болор толь" судар, зурмал бурхад зэрэг 17 шашны эд зүйлс; - Шарын гол сумын Мэргэн Даяанчийн Гэлэгпэлжээлин хийдэд хадгалагдаж буй 4 танка зураг; - | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эцэст: 50-иас доошгүй баримтат өвийг судалгаанд хамруулна. | Дархан сумын иргэн З.Ёндон ламд хадгалагдаж буй судар бичиг 3, гэрэл зураг 1, ил захидал 1 зэрэг 5 баримтат өв; - Үндэсний Төв Архиваас Дархан хотын түүхтэй холбоотой 5 бичиг баримт; - Дархан сумын иргэн марк цуглуулагч Д.Сайнхүүд хадгалагдаж буй 12 марк; - Хонгор сумын иргэн Лувсанжамцад хадгалагдаж буй 9 баримтат өвийг тус тус бүртгэн урьдчилсан жагсаалтыг бүрдүүлэв. Хүрсэн түвшин: Нийт 50 баримтат өвийг бүртгэн баримтжуулсан.<br>Хүрсэн түвшин: Тайлант хугацаанд иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа нийт 50 баримтат өвийг бүртгэл мэдээллийн санд бүртгэж, тайланг салбарын хяналтын https://moc.igovernment.mn/ цахим санд сар бүр оруулж баталгаажуулж ажиллав.<br>Хавсралт: 2 файл | |
| 1.2.5 | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийхэд дэмжлэг үзүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Тоологдсон түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоо | 2019 онд 969 дэсийн 1362 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тоологдсон. | Эхний хагас жилд: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг бүрэн хийж, холбогдох газарт тайлагнасан байна. Жилийн эцэст: Түүх, соёлын хөдлөх дурсгалт | 1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг улс орон даяар нэгдсэн журмаар III, IV улиралд зохион байгуулахтай холбогдуулан улсын тооллого хийх ажлын хэсгийг байгуулах тухай аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/19 дугаар Захирамжийг ЗГХА СУГ-т хүргүүлсэн. 2. Мөн Шарын гол, Орхон сумын Соёлын төвд СББӨ-ийг өвлөн уламжлагчдын тоо, чанарыг нэмэгдүүлэх, Музейн эд өлгийн зүйлийг бүртгэн баримтжуулах, Түүх, соёлын хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, холбогдох шинэ дүрэм журмыг таниулах зорилгоор “Түүх, Соёлын Үл Хөдлөх Дурсгалын тухай болон Дархан-Уул аймгийн дурсгалууд”, “Соёлын Биет Бус Өв, түүний төрөл тус аймгийн СББӨ-ийг өвлөн уламжлагчид”, "Соёлын үнэт зүйл худалдан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зүйлийн тооллогыг бүрэн хийж, холбогдох газарт тайлагнасан байна. | авах журам", "Сан хөмрөгт үзмэр оруулах гаргах хөдөлгөөн"-ий дүрэм сэдвүүдээр сургалт хийж арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. 3. Хонгор сумын Соёлын төвийн даргын 2024 оны "Эд хөрөнгийн тооллого явуулах тухай" тушаалын дагуу музейн ажилтныг оролцуулан хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг зохион байгуулсан. 4. Орхон сумын Соёлын Төвийн Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэрийн бүртгэл, тооллогод хяналт тавьж арга зүйн зөвлөгөө өгөв. 5. Бүртгэл тооллогод Хонгор сум 115 дэсийн 120, Орхон сум 28 дэсийн 31 үзмэрийг хамруулав.<br>Хүрсэн түвшин: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн Улсын тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан. Хонгор, Орхон сумдын соёлын төвийн Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэрийн бүртгэл, тооллогод хяналт тавьж арга зүйн зөвлөгөө өгөв. Бүртгэл тооллогод Хонгор сум 115 дэсийн 120, Орхон сум 28 дэсийн 31 үзмэрийг хамруулав. Тооллого зохион байгуулах урьдчилсан бэлтгэл хангагдсан.<br>Хавсралт: 5 файл | |
| 1.3. | Түүх, соёлын дурсгалын үзмэр, баяжилтыг нэмэгдүүлж, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна. | Батлагдсан төсөв | Нэмэгдсэн сан хөмрөгийн үзмэрийн тоо, боловсруулсан баримт бичгийн тоо, үйлчилгээний нэр төрөл, үйлчлүүлсэн | 33 дэсийн үзмэрээр баяжуулсан. Аймгийн Засаг даргын 2022 оны 01-А/343 дугаартай Захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Дархан-Уул | Сан хөмрөгийг баяжуулсан байна. Үзэл баримтлал, үзүүллэг, дэглэлтийн төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулсан | Аймгийн Музей нь нийт 16 дэсийн 16 ширхэг үзмэрийн баяжилт хийж нийт 1047 дэсийн 1465 ширхэг үзмэртэй болж өссөн. Орхон сумын Соёлын төвийн Музей хандиваар 5 үзмэрийн баяжилт хийгдсэн. Ингэснээр тус сумын музей нь нийт 36 үзмэртэй болсон. - Музейн үйл ажиллагаа эрхлэх "Тусгай зөвшөөрөл"-ийн гэрчилгээг хүлээн авсан. - Музей нь 418 үзвэр үйлчилгээг зохион байгуулж, 35848 хүнд хүрч үйлчилсэн байна. - Шинэ Музейн үзэл баримтлал, үзүүллэг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | иргэдийн тоо, | аймгийн нийт хүн амын 26 хувьд хүрч үйлчилсэн. | байна. Аймгийн нийт иргэдийн 20 хувиас багагүй иргэдэд музейн үйлчилгээ үзүүлсэн байна. 2-оос багагүй соёлын өвийг хамгаалах чиглэлийн хамтарсан доошгүй төсөл, хөтөлбөр дэмжсэн байна. | дэглэлт төлөвлөгөөг боловсруулж ССАЖЗЯаманд хүргүүлсэн. - Соёлын өвийг хамгаалах чиглэлийн хамтарсан 7 төсөл, хөтөлбөрийг дэмжсэн. Хавсралт: 3 файл | |
| 1.3.1 | Музейн сан хөмрөгийг баяжуулж, үзмэрүүдийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Нэмэгдсэн үзмэрийн тоо | 33 дэсийн 40 үзмэрээр баяжуулсан. | Эхний хагас жилд: Сан хөмрөгийг баяжуулсан байна. Жилийн эцэст: Сан хөмрөгийг баяжуулсан байна. | 2023-2024 онд ард иргэд, албан байгууллагаас ирүүлсэн 29 дэсийн Соёлын өвийн жагсаалтыг ББЗМаягтаар гарган, Үзмэр Худалдан авах Зөвлөлийн хурлаар оруулан "Давхарын өртөө" сүрлэн наамал-1ш, "Д.Сүхбаатар, В.И Ленин нарын уулзалт" сүрлэн наамал-1ш, "Хүннү ваар"-1ш, "Шавар ваар"-1ш, "Одос үхрийн эвэр бүхий дагзны яс"-1ш, "Пянз тоглуулагч"-1ш, "Аккордион хөгжим"-1ш, "Ногоолин чулуу"-1ш, "Ю.Цэдэнбал, И.Л Брежнев нарын уулзалт" уран зураг-1ш, "Баяр хуур" хөгжим-2 ширхэг, "Тольдохуй" уран зураг -1ш, "Элч" уран зураг-1ш, "Эг-Сэлэнгийн бэлчир" уран зураг-1ш, "Отгонтэнгэр" уран зураг-1ш, "1925 оны мөнгөн тэмдэгт 1 төгрөг -1ш нийт 16 дэсийн 16 ширхэг үзмэрийн баяжилтыг МУ-ын Сангийн Сайдын 2013 оны 140 дүгээр тушаалаар "Түүх, соёлын дурсгал, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам"-ын дагуу сан хөмрөгийн үнэлгээгээр үнэ тогтоож, бүртгэн авлаа. Орхон сумын Соёлын төвийн Музей хандиваар 5 үзмэрийн баяжилт хийсэн.<br>Хүрсэн түвшин: - Нийт 16 дэсийн 16 ширхэг үзмэрийн баяжилт хийгдэж, нийт 1047 дэсийн 1465 ширхэг үзмэртэй болж баяжигдсан. - Музейн байгалийн танхимын амьтадыг шинэчлэн зорилгоор Аймгийн Нийгмийн Бодлогын Газарт, Хөрөнгө оруулалтын Хөгжлийн Бодлогын газарт "Ан амьтад, шувуудын цуглуулга" нэртэй 45 дэсийн 55,075,000 төгрөг бүхий төслийн саналыг тус тус хүргүүлсэн - Орхон сумын Соёлын төвийн Музей хандиваар 5 үзмэрийн баяжилт хийсэн.<br>Хавсралт: 2 файл | |
| 1.3.2 | Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Боловсруулсан баримт бичгийн тоо | Аймгийн Засаг даргын 2022 оны 01-А/343 дугаартай Захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. | Эхний хагас жилд:<br>Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна. Үзэл баримтлал, үзүүллэг, дэглэлтийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.<br>Жилийн эцэст:<br>Музейн үйл ажиллагаа | 1. Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах ажлын хүрээнд шаардагдах материалуудыг Соёлын Яаманд цаг тухайд нь хүргүүлж ажилласан бөгөөд 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр 2024/8 дугаартай Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/12 дугаар тушаалаар Музейн үйл ажиллагаа эрхлэх "Тусгай зөвшөөрөл"-ийн гэрчилгээг гардаж авав. 2. "Шинэ Музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөө" боловсруулах ажлын хэсгийг Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022 оны 01-А/343 дугаар тоот захирамжаар байгуулсан. Улмаар Соёлын сайдын тушаалаар Үзал баримтлал боловсуулахад шаардлагатай 16.0 сая төгрөгийн эрх санхүүжилтийн эрх шилжиж ирсний дагуу О.Ангарагсүрэн, Ж.Мяндас нарын эрдэмтдийн багт Дархан-Уул аймгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна. Үзэл баримтлал, үзүүллэг, дэглэлтийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. | Музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөөг боловсруулах гэрээг байгуулж ажиллав. Ажлын хэсэг нь аймгийн ЗДТГ, холбогдох мэргэжлийн байгууллагын удирдлагууд, аймгийн иргэдтэй цахим уулзалт хийж, Музейн Угсаатны, Шашны, Түүхийн танхимд чийгшил температурын сенсор тусгай 4 ш багаж суурилуулан хэмжилт хийв. Тус газар болон аймгийн музейгээс Дархан хотын түүхтэй холбоотой эх сурвалжууд, угсаатны зүйн болон археологийн судалгаа, аймгийн нийт иргэдийн тоон мэдээлэл, 389 иргэнээс 10 төрлийн асуулга бүхий судалгааг цаасан хэлбэрээр авч төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт, 3D байгуулалт хийхэд зориул 50 орчим үзмэрийн гэрэл зургийг интерьерийн компанид тус тус хүргүүлэв. Музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөөний тайлангийн хурлыг 2024.06.11-нд хийж үр дүнг танилцуулав. Тус хурлаар Дархан-Уул аймгийн шинэ Музейг “Түүх, Угсаатны Музей” хэмээн нэрлэхээр шийдвэрлэж аймгийн Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагчид уг төлөвлөгөөг гардуулав. Мөн тус төлөвлөгөөнд санал авч баталгаажуулахаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 1ССАЖЗ-ын сайдын 2024 оны А/12 дугаар тушаалаар Музейн үйл ажиллагаа эрхлэх “Тусгай зөвшөөрөл”-ийг хүлээн авсан. 2.Аймгийн ЗД-ын 2022 оны 01-А/343 дугаартай захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг “Шинэ Музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөө”-г боловсруулсан. Уг төлөвлөгөөнд санал авч баталгаажуулахаар салбарын яаманд хүргүүлэв. 3.Музейг “Түүх, Угсаатны Музей” хэмээн нэрлэхээр шийдвэрлэсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хавсралт: 3 файл | |
| 1.3.3 | Музейн үйлчилгээний нэр төрлийг олшруулах замаар үйлчлүүлсэн иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Үйлчилгээний нэр төрөл, үйлчлүүлсэн иргэдийн тоо | Дархан-Уул аймгийн нийт хүн амын 26 хувьд хүрч үйлчилсэн. | Эхний хагас жилд: Аймгийн нийт иргэдэд музейн үйлчилгээ үзүүлсэн байна. Жилийн эцэст: Аймгийн нийт иргэдийн 20 хувиас багагүй иргэдэд музейн үйлчилгээ үзүүлсэн байна. | - Музей нь 418 үзвэр үйлчилгээг зохион байгулж, 44,445 хүнд үйлчилсэн бөгөөд аймгийн нийт хүн амын 41,1%-д хүрч үйлчилсэн байна. Үүнд: - Байнгын үзүүллэгийн 4 танхимаар 10566 үзэгч, түр үзэсгэлэн 17 зохион байгуулснаас 12 нь дотоодын, 5 нь хамтарсан үзэсгэлэнг нийт 14701 үзэгчдэд толилуулсан. - “Дарханы түүх, соёл: эрт эдүгээ” ЭШХ-д 130 оролцогч хамруулсан. - 23 төрлийн сургалт арга хэмжээ зохион байгуулж, 1030 хүн хамруулсан. - Музейн боловсролын хөтөлбөрийг 370 удаа зохион байгуулж, 9371 оролцогч хамруулсан. Үүнд танхимаар 139 удаагийн оролтоор 4219 оролцогч хамруулсан. - Нүүдлийн боловсролын хөтөлбөрийг 231 удаагийн оролтоор 5152 иргэн хамруулсан. - Дижитал үйлчилгээг 1 удаа зохион байгуулж, 50 оролцогчийг тус тус хамруулсан. - 2024 оны 12 дугаар сарын байдлаар 18.000.000 сая төгрөгийн орлогыг Төрийн санд төвлөрүүлсэн байна.<br>Хүрсэн түвшин: Музей нь 418 үзвэр үйлчилгээг зохион байгулж, 44,445 хүнд үйлчилсэн бөгөөд аймгийн нийт хүн амын 41,1%-д хүрч үйлчилсэн байна. Үүнд: Байнгын үзүүллэгийн танхимаар 10566 үзэгч, түр үзэсгэлэн 17 удаа зохион байгуулсанаас 14701 үзэгчдэд толилуулсан байна. Музейн боловсролын хөтөлбөрийг 370 удаа зохион байгуулж, 9371 оролцогч хамруулсан. Нүүдлийн боловсролын хөтөлбөрийг 231 удаагийн оролтоор 5152 иргэн хамруулсан. Дижитал үйлчилгээг 1 удаа зохион байгуулж, 50 оролцогчийг тус тус хамруулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хавсралт: 12 файл | |
| 1.3.4 | Төр, хувийн хэвшил, орон нутгийн байгууллага болон иргэний нийгмийн байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлж, соёлын өвийг хамгаалах чиглэлийн хамтарсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хамтран хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо | - | Эхний хагас жилд: Соёлын өвийг хамгаалах чиглэлийн хамтарсан доошгүй төсөл, хөтөлбөр дэмжсэн байна. Жилийн эцэст: 2-оос багагүй соёлын өвийг хамгаалах чиглэлийн хамтарсан доошгүй төсөл, хөтөлбөр дэмжсэн байна. | 1. Аймгийн музейн Сан хөмрөгт хадгалагдаж буй 9 төрлийн хөлөгт тоглоомыг судалгааны эргэлтэд оруулах, иргэдэд СББӨ-ийг түгээн дэлгэрүүлэх, уламжлалт тоглоом наадгайг сурталчлах зорилгоор “Хөөрхөн Нада” хөлөгт наадгайн тоглоомын багц 80 ширхэг “Нада аялал найрамдлын музейд” комик зургийн номыг 300 ширхэг “Оньсон хүү” ХХК-д үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж борлуулав. 2. "Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл" өвийг түгээн дэлгэрүүлэх, Монголын өв уламжлал, соёлын үнэт зүйлсийг сурталчлан таниулах, үр хойчдоо өвлүүлэх зорилготой “Гэр” үзэсгэлэнгийн хүрээнд Дарханы Зураач, урчуудын эвлэлийн гишүүн, MOZU брэндийг үүсгэн байгуулагч 2 зураачтай монгол зургаар чимэглэсэн халх монгол гэрийг бүтээх, урлах 30,370,000 төгрөгийн төслийг гэрээ байгуулж хамтран ажилласан. 3. Шинэ үе хамтын холбоо ТББ, Тусгай хэрэгцээт залуучуудыг дэмжих "УРАМ" төвөөс санаачлан хэрэгжүүлж буй "МОНГОЛ НААДГАЙ" хөлөгт тоглоомыг хэвлэхэд бодлогын дэмжлэг үзүүлсэн. Тус тоглоом нь 5 цуврал, 80 хөлөгтэй, 89 тоглоомтой, Цахим QR тайлбартай хөлөгт тоглоомыг 4. ЮНЕСКО, Соёлын яамны дэмжлэгтэйгээр СУИС-ийн Соёлын сургуулиас хэрэгжүүлж буй “Монгол бий биелгээг өвлүүлэн уламжлуулж, оршин тогтнох чадварыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Бий биелгээний шавь сургалтын танхим”-ыг Хүүхдийн номын ордныг түшиглэн тус танхимыг нээсэн. 5. Монгол Улсын Соёлын Сайдын 2024 оны А/255 тушаалын дагуу Монгол-Солонгосын соёлын өвийн судалгаа, шинжилгээ хийх зорилготой Хонгор сумын нутаг Цагаан овоот ууланд Булш оршуулга, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суурин газар, хөшөө чулуу дурсгалт газарт хийсэн нэг сарын хугацаатай судалгааны ажилд хяналт тавьж ажилласан. /2024.06.02-07. 02-ныг хүртэл/ 6.Шарын гол сумын Соёлын төвийн шинэ Музейг аймгийн орон нутгийн 76 сая төгрөгийн төсвөөр санхүүжүүлж их засварын ажил хийж гүйцэтгэсэн. 7.Орхон сумын музейн үзмэрийн хадгалалтыг сайжруулах хэрэгжилтийг хангуулахаар орон нутгийн 9,650,000 төгрөгийн санхүүжилтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр 2025 оны төсөвт тусгасан.<br>Хүрсэн түвшин: Соёлын өвийг хамгаалах чиглэлийн хамтарсан 7 төсөл, хөтөлбөрийг дэмжсэн байна.<br>Хавсралт: 10 файл | |
| 1.4. | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг нээн илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагааг бүх шатанд эрчимжүүлнэ. | Батлагдсан төсөв | Шинээр бүртгэгдсэн соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын тоо, үйл ажиллагааны тоо, оролцооны байдал хангагдсан эсэх | Соёлын биет бус өвийн бүсчилсэн үзлэг, судалгаанд 10 өвлөн уламжлагчийг шинээр бүртгэсэн. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг алдаршуулах тоглолт, өдөрлөг, контент зэрэг нийт 20 гаруй арга хэмжээг зохион байгуулсан. Соёлын биет бус өвийг өвлөн | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг нээн илрүүлж бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, 6-аас доошгүй үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. Оролцоо хангагдсан байна. 2-оос доошгүй арга | - МУ-аас ЮНЕСКО-ийн жагсаалтад орсон СББӨ-ийг өвлөсөн 29 өвлөн уламжлагчид БАТЛАМЖ гардуулав. - Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг сурталчлан алдаршуулах 26 арга хэмжээнд давхардсан тоогоор 55 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг оролцуулсан. - СББӨ-ийн 7 ай савыг эзэмшсэн 18 өвлөн уламжлагдад хүндэтгэл үзүүлэв. - Соёлын өвд учрах аюулыг бууруулах, авран хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 7 арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн. Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд оролцох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Аймгийн Засаг даргын 2024.07.03-ны өдрийн 01-А/315 дугаар захирамжаар 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Аймгийн ЗДТГ-ын даргын 2024.08.06-ны өдрийн 02-А/139 дүгээр тушаалаар 28.0 сая төгрөгийн, ЗГХАСУГ-ын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | уламжлагч 15, мэргэжлийн уран бүтээлч 24, бусад оролцогч 19 буюу нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. | хэмжээнд дэмжлэг үзүүлж ажилласан байна. | даргын 2024 оны А/32, А/58 дугаар тушаалаар нийтдээ 20.0 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгогдсон. Энэ хүрээнд 31 заалт бүхий төлөвлөгөө гарган аймгийн Засаг даргын орлогчоор батлуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулж тайлагнасан. Дархан-Уул аймгаа төлөөлөн оролцох "Найрамдлын Дархан" отгын зохион байгуулагчаар Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Энхбаярыг тус газрын даргын 2024.08.12-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар томилж, баг бүрэлдэхүүнийг өндөр түвшинд зохион байгуулж, бусад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг үүрэгжүүлж биелэлтийг бүрэн хангуулсан.<br>Хавсралт: 5 файл | |
| 1.4.1 | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг нээн илрүүлж, бүртгэл, мэдээллийн санд бүртгэх, тэдгээрийг сурталчлан алдаршуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Шинээр бүртгэгдсэн соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын тоо | Соёлын биет бус өвийн бүсчилсэн үзлэг, судалгаанд 10 өвлөн уламжлагчийг шинээр бүртгэсэн. СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг алдаршуулах тоглолт, өдөрлөг, контент зэрэг нийт 20 гаруй арга хэмжээг зохион байгуулсан. | Эхний хагас жилд: Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг нээн илрүүлж бүртгэл, мэдээллийн санд бүртгэсэн байна. 3-аас доошгүй үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. Жилийн эцэст: Соёлын биет | 1. Тус аймгийн хэмжээнд 84 өвлөн уламжлагч www.ich.mongoluv.mn улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй байдаг ба үүнээс МУ-аас ЮНЕСКО-ийн жагсаалтад орсон Морин хуур, Монгол Ардын уртын дуу, Монгол бий биелгээ, Монголын Уламжлалт Хөөмийн урлаг, Монгол уран бичлэг зэрэг өвийг өвлөсөн 4 сумын харьяат 29 өвлөн уламжлагчид БАТЛАМЖ гардуулж ЮНЕСКО-ийн яаралтай болон төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн өвийг өвлөн уламжилж, хойч үедээ түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн үлдээх үүргээ биелүүлж буйд Талархал илэрхийлэв. 2. ЮНЕСКО, Соёлын яамны дэмжлэгтэйгээр СУИС-ийн Соёлын сургуулиас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “Бий биелгээний шавь сургалтын танхим”-ын нээлтэд 12, Хэл хуурчдын анхдугаар чуулганд 3, “Монгол улсын шилдэг өвлөн уламжлагч” номинацид 1, “Мөнгөн мод 2023” наадамд 3, “Монгол туургатан хэл хуурын танхим байгуулах” 1, "Өв соёлоо дээдэлье" тоглолтод 12, МҮОНТ- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бус өвийг өвлөн уламжлагчдыг нээн илрүүлж бүртгэл, мэдээллийн санд бүртгэсэн байна. -аас доошгүй үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | ийн “Монгол Түмний Мэнд” нэвтрүүлэгт СББӨ-ийг өвлөн уламжлагч гэр бүлийн 5 гишүүнийг, "21 Өв, соёл" нэвтрүүлэгт 1, СББӨ-ийг өвлөн уламжлагчийн 17 ярилцлага, нэвтрүүлгийг RGB, ЦЭЦ.мн телевизүүдээр зэрэг 26 арга хэмжээнд давхардсан тоогоор 55 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг оролцуулж, сурталчилсан. 3.Соёлын бүтээлч сар 2024 аяны хүрээнд тус газраас Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчдыг алдаршуулах өдөрлөг арга хэмжээг зохион байгуулав. Өдөрлөгт Соёлын биет бус өвийн 7 ай савыг эзэмшсэн 18 өвлөн уламжлагч нар хамрагдав.<br>Хүрсэн түвшин: Улсын нэгдсэн www.ich.mongoluv.mn бүртгэл мэдээллийн санд шинээр 6 өвлөн уламжлагч бүртгэсэн. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг сурталчлан алдаршуулах 26 арга хэмжээнд давхардсан тоогоор 55 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг оролцуулсан. СББӨ-ийн 7 ай савыг эзэмшсэн 18 өвлөн уламжлагдад хүндэтгэл үзүүлэв.<br>Хавсралт: 9 файл | |
| 1.4.2 | “Нүүдэлчин” дэлхийн фестивальд оролцож, соёлын биет бус өвийг сурталчлан таниулна. | Улсын болон орон нутгийн төсөв | Оролцооны байдал хангагдсан эсэх | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 15, мэргэжлийн уран бүтээлч 24, бусад оролцогч 19 буюу нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. | Эхний хагас жилд: Оролцоо хангагдсан байна. Жилийн эцэст: Оролцоо хангагдсан байна. | “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт орших Тайж хайрханы бэлд 2024 оны 08 дугаар сарын 16-аас 18-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Дархан-Уул аймгаас аймгийн Засаг Даргын орлогч, Ажлын хэсгийн дарга Б.Жавхлангаар ахлуулан үндсэн оролцогч - 40, зохион байгуулалтад ажиллах-18 нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. - Залуучууд театрын болон СББӨ-ийг өвлөн уламжлагч нийт 27 уран бүтээлч нь 13 уран бүтээлийг отогт, тайзнаа 5 уран бүтээлийг тус тус толилууллаа. Тус | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | фестивальд оролцоход төсвийн төслийг боловсруулж хүргүүлснээр Аймгийн ЗДТГ-ын газраас 28.0 сая төгрөгийг, ЗГХА- Соёл, урлагийн газраас 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон. Дархан-Уул аймгийн хувьд соёлын биет бус өвийн 90 өвлөн уламжлагч бүртгэлтэй байдаг. Тухайлбал: Зан үйл, язгуур урлагийн багт Дархан-Уул аймгийн Залуучууд театрын найруулагч Н.Баярцэнгэл ахлагчтай 17 уран бүтээлчид, бага насны өвлөн уламжлагч 4 хүүхэд, МУСТА, Ерөөлч, магтаалч Дүйнхэрсүрэн, МУСТА, хулсан хуурч Жавзанжав, Ерөөл магтаал, уртын дуу Б.Дарханням, Хотон бий биелгээ Б.Таамж, Ш.Амгалан, Домбор хөгжимчин М.Давани зэрэг 30 гаруй соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч, Ардын авьяастнууд багтсан бөгөөд тэд 3 өдрийн туршид зан үйл, язгуур хэв шинж, нутгийн болон угсаатны онцлогийг харуулсан урлагийн тоглолтыг толилуулсан. Гар урлалын гэрт аймгийн зураач урчуудын холбооны тэргүүн Н.Хишигбаатар, эсгий урлаач Т.Жаргалсайхан, Монгол дархан, сийлбэрч Г.Эрдэнэтөгс, уран хатгамалч Б.Цэрэнбалжид гар урлалын бүтээлүүдээрээ оролцож байгаа бөгөөд Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэгч Ж.Эрхэмсайхан эртний түүхт хуйлмал номыг урлан, мянган жилийн буурал түүхтэй монгол бичиг соёлын бүтээлүүд, Б.Булганчимэг Найрамдлын Дархан, Үлэмжийн тансаг цуврал бүтээлээрээ тус тус оролцлоо.Харин соёлын бүтээлч үйлдвэрлэлийн асарт Соёлын биет бус өв, соёлын бүтээлч үйлвэрлэл, “Урам төв”-ийн Монгол наадгай Хөлөгт тоглоом, худалдаа, арьс шир эсгий бүтээгдэхүүний худалдаа явагдав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: Аймгийн Засаг Даргын орлогч, ажлын хэсгийн дарга Б.Жавхлангаар ахлуулсан үндсэн оролцогч 40, зохион байгуулалтад ажиллах 18 нийт 58 хүний бүрэлдэхүүн 4 гэр, 1 асартайгаар оролцлоо. Нийт 27 уран бүтээлч ажиллаж 13 уран бүтээлийг отгийн гадна талбайд нийт 14 удаа, Хүндэтгэлийн тайзнаа 5 уран бүтээлийг 1 удаа тус тус тоглов. Хамтарсан Гала тоглолтод 1 уран бүтээлийг тоглосон. Зан үйл, язгуур урлагийн өргөө, СББӨ-ийн өргөө, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн асар, уламжлалт хоол, идээгээр оролцлоо.<br><br>Хавсралт: 9 файл | |
| 1.4.3 | Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл зэрэг, давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгааны улмаас соёлын өвд учирсан хохирлыг бууруулах, авран хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо | 2 арга хэмжээг хэрэгжүүлсэн. | Эхний хагас жилд: Арга хэмжээнд дэмжлэг үзүүлж ажилласан байна. Жилийн эцэст: 2-оос доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлж ажилласан байна. | 1. Аймгийн нутагт орших нурж унах эрсдэлд орсон 2, унаган газраас зөөгдсөн 2, төв суурин газар, бүтээн байгуулалтад өртөж эх төрх нь алдагдсан 3, Улсын болон хөдөө орон нутгийн замд өртсөн 4, бичиж балласан, сийлж сүйтгэсэн 1, хадаг бөс даавуугаар ороосон, сүү тосны бохирдолд орсон 1 зэрэг ТСҮХД-ын мэдээллийг бэлтгэж СӨҮТ-д хүргүүлэв. 2. Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэрүүдийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор “Ачаа ачигч”, “Мөнх найрамдлын тууль”, “Мөнх найрамдал”, “Давхарын өртөө”, “Их нүүдэл”, “Үйлдвэрийн Дархан” зэрэг 6 уран зургийг СӨҮТ-рүү актаар хүлээлцэн хүргэх ажлыг соёлын өвийг зөөж тээвэрлэх журмын дагуу гүйцэтгэсэн. 3. “Практикал даатгал”-тай хамтран даатгалын гэрээг хийж 3 соёлын биет өвийг даатгуулсан. 4. Хараагийн Дара эх ламын Гэцогдаржайлин хийдэд хадгалагдаж буй 53 дэсийн 61 ширхэг эд өлгийн зүйлсийг (цаасан хэлбэрээр) хадгалалт хамгаалалтыг сайжруулах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зорилгоор бүртгэн баримтжуулсан. Үүнд: Шашны холбогдолтой үзмэр 47, урлаг уран сайхны холбогдолтой үзмэр 6-г тус тус бүртгэн баримтжуулж, тус хийдэд бүртгэлийн жагсаалт, ажлын тайланг хүлээлгэн өгөв. 5. Тус хийдэд хадгалагдаж буй соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, хэрхэн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх талаар арга зүйн сургалтыг зохион байгуулав. 6. Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн Музейн ажилтнууд аймаг, сумдын музейн ажилтнуудыг чадавхжуулав. 7. Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулж буй ЮНЕСКО-ийн Зүүн хойд Азийн төлөөлөгчийн газартай хамтарсан "Уур амьсгалын өөрчлөлт, түүний нөлөөлөлд өртөж буй соёлын өвийг судлах, хамгаалах мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх" 5 хоногийн сургалтад аймгийн Музей, Соёлын төвийн Музейн ажилтнууд хамрагдав<br>Хүрсэн түвшин: Соёлын өвд учрах аюулыг бууруулах, авран хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 7 арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.<br>Хавсралт: 7 файл | |
| 1.5. | Соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Нэмэгдсэн уран бүтээлийн тоо, үзэгчийн тоо, уралдаан тэмцээний тоо болон оролцогчдын тоо, арга хэмжээний | Театрын урын санд шинээр 7 уран бүтээл нэмэгдсэн. Улсын болон олон улсын чанартай 20 удаагийн уралдаан тэмцээнд 300 гаруй | 1-ээс доошгүй уран бүтээл туурвиж үзэгчдийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлсэн байна. Уран бүтээлч, | 1. Залуучууд театрын уран бүтээлчид нь сар шинийн баяраар “Ардын дууны түрлэг” цахим концертыг найруулан тавьж 3800 үзэгчдэд хүргэсэн. 2. “Өнөд өвлөгдөх өв” концерт нь олон ястны дуу хуур, бүжиг наадам, соёлын биет бус өвийг өвлөн уламжлах, сурталчлан таниулах зорилготой бөгөөд Дархан-Уул аймагт амьдран суудаг олон ястнуудын өв соёлоос зохиомжлон 18-20 номертой бүрэн хэмжээний бүтээлийг 2 удаа тоглож нийт 1182 ард иргэдийг хамрууллаа. Тус уран бүтээлд 32 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тоо | оролцогчдод дэмжлэг үзүүлсэн. Хүүхдэд зориулсан уран бүтээл 3 | хүүхэд залуучуудыг 5-аас доошгүй уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлсэн байна. 1-ээс доошгүй уран бүтээл 3-аас доошгүй арга хэмжээг дэмжсэн байна. | 668 200 төгрөгийн зардал гаргаж, хөгжмийн найруулага, зохиол, гэрээгээр уран бүтээлчдийн ажлын хөлс, тайз хувцас худалдан авсан байна. 3. Шарын гол сумын Соёлын төв нь сар шинийн баяраар “Тал нутгийн залуус", "Наргиант бий", "Тойрон бүжиг" бүжгийг тавьж 670 үзэгчдэд толилууллаа. Мөн “Наурыз”-ын баярын урлагийн тоглолтыг зохион байгуулж 1000 гаруй иргэдэд хүргэсэн. 4. Хонгор сумын Соёлын төв нь сар шинийн хүндэтгэлийн тоглолтыг 120 гаруй ахмадуудад толилууллаа. 5. Орхон сумын Соёлын төв нь “Сэтгэлийн хэлхээ”, “Өв соёлоо дээдэлье” зэрэг 3 тоглолтыг 1604 үзэгчид хүргэлээ.<br>Хавсралт: 5 файл | |
| 1.5.1 | Мэргэжлийн урлагийн байгууллагын урын сан дахь уран бүтээлийг цахим хэлбэрт шилжүүлэн сан бүрдүүлж, цахим орчинд түгээх, орон нутгийн телевизээр дамжуулан иргэдэд хүргэхэд дэмжлэг үзүүлэх | Батлагдсан төсвийн хүрээнд | Үзэгчдийн тоо | - | Эхний хагас жилд: Урын сангийн ноот бичвэрийг цахим хэлбэрт оруулах, уран бүтээлийг цахимжуулж хүн амын тодорхой хувьд хүргэсэн байна. Жилийн эцэст: Урын сангийн ноот бичвэрийн 50 хувийг цахим хэлбэрт оруулах, уран | 1. Залуучууд театрын уран бүтээлийн архивт хөгжмийн зохиолчдын туурвисан,үндэсний хөгжимд зориулан хөрвүүлсэн 563 нэр төрлийн нот клавир хадгалагдаж байна.Нийт 3 боть буюу нийт 356 нот, клавир буюу 3563 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн. 2. Муурын байшин хүүхдийн жүжгийн бичлэгийг архивлаж 2021 оны тус театрын бүтээл Хамгийн сайхан хот кино концертыг 6 хэсэгт хуваан цахимд байршуулж 75000, Ардын дууны түрлэг цахим концерт -3800, Дуучин Д.Бибишийн Буурлын нутаг -16000, Хан хөхүй минь түшигтэй – 14000, Хамгийн сайхан хот кино концерт- 1200,Дуучин Б.Соронзонболд Эсгий тоорцог- 39000,Дуучин Б.Бат-Эрдэнэ Би Монгол хүн –14000,Дуучин С.Сүхбат Шөнө амталсан нулимс-34000, Хүмүүний нэгэн урсгал – 109000, "Мандах нар” -3100, Дуучин Н.Бадрангуйхурц Ганган мэдрэмж – 346000,Бүжигчин Б.Ариунжаргал ТЭНГЭРИЙН БҮЖИГ тоглолт – 17000,Өнөд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүтээлийг цахимжуулж хүн амын 25-аас доошгүй хувьд хүргэсэн байна. | өвлөгдөх аялгуу тоглолт– 8200, Наадмын нээлтийн тоглолт – 13000,Найрамдлын Дархан тоглолт – 94000, "Халхын гол тангараг" жүжиг -985, Жүжигчин, МУСТА Ч.Дунгаамаа Моно жүжгийн олон улсын наадамд оролцож ШИЛДЭГ ЭМЭГТЭЙ ЖҮЖИГЧИНээр шалгарсан– 61000,БИДНИЙ БАХАРХАЛ" уулзалт /МУГЖ Ш.Дэлгэржаргал, МУСТА, ахмад дуучин Б.Содонбаяр/ – 27000,4 аймгийн театрын хамтарсан "Уухайн түрлэгт эх орон минь" нэгдсэн тоглолт – 9500,Морин хуурч МУСТА Д.Баттулга “Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх тухай” зарлигийн дагуу морин хуурын сургалт – 989,Залуучууд театр "Соёлын бүтээлч сар"-ын нээлт -4900, Дэлхийн бүжигчдийн өдрийн баярын ярилцлага – 1600 зэрэг нийт 13 уран бүтээлийг цахимд байршуулж иргэд олон нийтэд сурталчилсан. 3.Орон нутгийн RGB, DBS, Цэц.мн зэрэг 3 хэвлэл мэдээллийн байгууллагатай 3.5 сая төгрөгийн хамтран ажиллах гэрээ байгуулсан. DBS-7, Цэц.мн-12, RGB-41 нийт 60 мэдээг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан иргэд, олон нийтэд сурталчилсан. 4.2024.09.01-ний өдрөөс эхлэн Монгол HD телевизийн Өглөө хөтөлбөрт 7 хоног бүрийн Мягмар гарагт онцлох 2 мэдээ бэлтгэн, нийт 26 үйл ажиллагааны талаарх мэдээллийг сурталчилсан.<br>Хүрсэн түвшин: Театрын урын сангийн архивт хөгжмийн зохиолчдын туурвисан болон үндэсний хөгжимд зориулан хөрвүүлсэн 563 нэр төрлийн нот клавир хадгалагдаж байна.Уран бүтээлийн архивт хадгалагдаж байгаа нот, клавирыг цахим хэлбэрт оруулан сан хөмрөг үүсгэх ажил 65%-тай явагдаж байна.Нийт 3 боть буюу нийт 356 нот,клавир буюу 3563 хуудас | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн ажилласан.Нийт 2 жүжиг,6 цахим концерт,6 уран бүтээлчийн дуу,бүжгийн 3 уран бүтээлчийн бүжгийн бичлэгийг цахимд нийтэлж 893274 үзэгчдэд хүргэсэн<br>Хавсралт: 1 файл | |
